



**БАЯНГОЛ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2018 оны 01 сарын 20 өдөр

Дугаар А/62

Улаанбаатар хот

**Газар эзэмших эрхийн гэрчилгээ
олгох тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, "Газрын тухай" хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5.3 дахь заалт, нийслэлийн Засаг даргын 2014 оны 301 дүгээр захирамжийн нэгдүгээр хавсралт дахь Хүүгийн Түмэнбаярт холбогдох хэсэг, Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 364 дүгээр тогтоол, Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 300 дугаар тогтоол, захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2017 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 221/МА2017/0436 дугаар магадлал, Монгол улсын дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны 2017 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 316 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Баянгол дүүргийн 16 дугаар хорооны Туулын 13-24 тоот хашааны 446 м.кв газрыг гэр бүлийн хамтын хэрэгцээний зориулалтаар иргэн Д.Мөнхбатад эзэмшүүлсүгэй.

2. Д.Мөнхбатад газар эзэмших эрхийн гэрчилгээ олгож гэрээ байгуулахыг Газрын алба /Г.Мөнхбаатар/-нд даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



С.ОДОНТУЯА